

## Материалимпэкс ХК-ийн 2017 оны жилийн Үйл ажиллагааны тайлан

### Агуулга

- Компанийн түүхэн замнал
- Эрхэм зорилго, зорилт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга
- Компанийн бүтэц
- Хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ
- Хараат бус аудиторын тайлан

### ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монгол Улсад үйлдвэр, орон сууц, нийтийн аж ахуй, хөдөө аж ахуйн барилга байгууламж барьж байгуулах ажлыг цаашид эрчимтэй хөгжүүлэх талаар нам, засгаас тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, ЗХУ болон социалист бусад орноос зээл тусламжаар болон худалдааны шугамаар авч байсан, түүнчлэн дотоодын үйлдвэрүүдээс гаргаж байсан материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хүлээн авах, хадгалах, хэрэглэгч байгууллагуудад нийлүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх байгууллагыг МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1957 оны 3-р сарын 28-ны 108-р тогтоолоор Гадаад худалдааны яамны харьяанд Техник туслалцааны бааз нэртэйгээр байгуулсан нь одоогийн “Материалимпэкс” ХК юм.

Техник туслалцааны бааз нь эхний үед ГХЯ-ны харьяа Бөөний худалдааны баазтай нэг дор ажиллаж байгаад удалгүй хангамжийн болон хэрэглэгч байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах үүднээс Сайд нарын Зөвлөл 1958 оны 8-р сарын 10-ны өдрийн 46-р тогтоолоор Улсын барилгын хорооны харьяанд шилжүүлжээ. Тус бааз байгуулагдахдаа 508,000 төгрөгийн үндсэн, 4.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, цехэд–10, санхүүгийн–9, үндсэн ба туслах ажилчин–170 байв.

Материалимпэкс ХК нь өдгөө гадаад дотоод худалдаа, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, улс хоорондын тээвэр зуучлал, аялал жуулчлал, ажлын байрны түрээс, агуулахын аж ахуй гэсэн үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын шилдэг 100 аж ахуйн нэгжээр удаа дараа шалгарсан томоохон компаниудын нэг болон өргөжлөө.

## КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Манай компанийн эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдийн найдвартай түнш байж, өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар улс эх орон, нийслэл хотын нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, улмаар ажиллагсдынхаа бодит орлогыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгох, компанийн хөрөнгө санхүүгийн тогтвортой байдлыг бий болгоход оршино.

Бидний зорилт - барилгын болон хүнсний салбарт гадаадын үйлдвэрлэгчдийг дотооддоо холбох түүчээ болох, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Сайн засаглалыг хэрэгжүүлэгч, үлгэр жишээ хувьцаат компани болох

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. ТУЗ-ийн дарга – Гомбын Аюушмаа. 1942 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй.

2. ТУЗ-ийн ердийн гишүүд:

2.1 Баярын Зориг. 1953 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, барилгын инженер мэргэжилтэй. Монгол улсын Зөвлөх инженер

2.2 Дагвын Оюун. 1973 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч, санхүүч мэргэжилтэй.

2.3 Чулууны Чинзориг. 1973 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй.

2.4 Төмөрбаатарын Мөнхжаргал. 1982 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.

2.5 Ням-Осорын Мягмарсүрэн. 1986 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй. Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, татварын итгэмжит нягтлан бодогч.

3. Хараат бус гишүүд:

3.1 Доржийн Эрдэнэцэцэг. 1973 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.

3.2 Даваанямын Үнэнзаяа. 1973 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.

3.3 Чойсүрэнгийн Энхтуул. 1979 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, сэтгүүлч мэргэжилтэй.

## Хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

Тус компани тайлант хугацаанд гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор 2 алба, 5 хэлтэс, 4 нэгжтэйгээр үйл ажиллагаа явууллаа.

Захиргаа, үйлчилгээний хэлтсийн чиг үүрэг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгын хүрээнд хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг нэгтгэх, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах, ажиллагсдаа мэргэшүүлэх, байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, төсөв хөрөнгийг төлөвлөн, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, ажиллагсдын ажил үүрэгт нь тохирсон бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалин хөлсний зохицуулалт хийх, төрийн болон хувийн хэвшлийн гадна дотны байгууллагуудтай харьцах, удирдлагын баримт бичиг, гэрээ хэлцэлүүд, захирлын тушаал боловсруулж, тэдгээрийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих ажиллагааг гүйцэтгэхээс гадна компанийн дотоод үйлчилгээ, цэвэрлэгээ, харуул хамгаалалтын ажлыг хариуцах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу явуулах зэрэг ажил үүргийг өдөр тутамдаа хэрэгжүүлдэг.

Материалимпэкс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 08 тоот тогтоолоор компанийн бүтэц, орон тоо, албан тушаалын нэрсийн жагсаалт, цалингийн сүлжээг шинэчлэн баталж, тайлант хугацаанд Захиргаа, үйлчилгээний хэлтсийн 19, борлуулалтын алба 4, орон сууцны ашиглалтын алба 12, санхүү эдийн засгийн хэлтэс 9, гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс 8, гаалийн хяналтын бүс 4, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс 1, үйлдвэр, техникийн хэлтэс 13, бетон зуурмагийн үйлдвэр 4, нийт 74 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явууллаа.

Компанийн Удирдах ажилтны “Шуурхай зөвлөгөөн”-ийг долоо хоног бүрийн Мягмар гаригт зохион байгуулж, цаг үеийн болон тулгамдаж буй асуудлын хүрээнд 2017 онд нийт 24 удаа хуралджээ.

Байгууллагын дотоод удирдлагын системийн “Хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэлийн удирдлага”-ын “ZKTeco Attendance Management” программыг албан хэрэгцээнд ашиглан, Хүний нөөцийн дэд программд компанийн нийт ажилтан, албан хаагчдыг бүртгэлжүүлж, албан тушаалд шинээр томилогдсон болон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчдын бүртгэл мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр хийж, баяжилтийн нэгдсэн бааз үүсгэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд 83 албан бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, нэгжид танилцуулан, 12 албан бичигт дурдсан хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Төрийн байгууллага, албан тушаалтан, харилцагч аж ахуйн нэгж, иргэдэд хандаж нийт 495 албан бичиг илгээжээ.

Худалдах худалдан авах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, түрээсийн, даатгалын зэрэг 10 гаруй төрлийн 103 гэрээг байгууллага, хувь хүнтэй хийсэн байна.

Албан тушаалын сул орон тоонд тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг зааж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй зар түгээж, ил тод, багаар сонгон шалгаруулан ажил, албан тушаалд томилж, сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан. Тайлант хугацаанд захирлын 60 тушаал гарсан байна.

Компанийн ажилтан, албан хаагч, ажиллаж байсан ахмад 10 хүнд 1,8 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгожээ.

Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдаас компанийн хэрэгжүүлж буй төслийн орон сууцнаас худалдан авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэх, ипотекийн зээлд хамруулах ажлыг удирдлагын зүгээс дэмжин ажиллаж байна.

### Борлуулалтын алба

Борлуулалтын албаны үндсэн чиг үүрэг нь бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах менежмент, маркетингийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх явдал юм.

Иймд бид 2017 онд **TV5** – Үл хөдлөх хөрөнгийн нэвтрүүлэг, 7 хоногийн 2 удаагийн цацалтаар нийт 192 удаагийн нэвтрүүлэг, **TV25- BUSINESS TIMES** нэвтрүүлэг, 7 хоногийн 3 удаагийн цацалтаар нийт 288 удаагийн нэвтрүүлэг, **EAGLE TV- MEDIA EXPO** нэвтрүүлэг. Нийт 12 удаагийн нэвтрүүлэг тус тус хийж, идэвхжүүлэлт хийжээ.

Манай хэлтсийн хамт олон өдөр тутамдаа

- Худалдан авагчдад хорооллын иж бүрэн танилцуулга хийх
- Загварын байр үзүүлж мэдээллээр хангах
- Захиалгын гэрээ хийх
- Арилжааны банктэй ипотекийн 8%-н зээлийн асуудлаар хамтарч ажиллах
- Худалдан авагчдад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг авахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгөх
- Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанитай хамтарч ажиллах
- Хөрөнгө оруулагч талын удирдлага болон ажилтнуудтай санал солилцож, тулгарч буй асуудлууд дээр хамтарч ажиллах
- Дулаан зогсоолын түрээсийн гэрээ хийж тооцоонд хяналт тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Мөн жил бүрийн барилга, орон сууцны 2017 оны хавар, намрын үзэсгэлэн худалдаа, МҮХАҮТ-аас зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд оролцлоо. Нэг удаагийн үзэсгэлэн худалдаанд **2000-6000** ширхэг танилцуулга тараагдсан байна.

**ЦАХИМ ОРЧИНД борлуулалтын талаарх мэдээллийг** Интернет, вэбсайт, Facebook / barilga.mn, oronsuuts.mn, shinebair.mn, Happyhome.mn, MY TOWN-Materialimpex ХК/

360 градус Виртуал аялал / Zochin360.mn/Mytown, Happyhome.mn/

байнгын одоог хүртэл байршиж байгаа. Холбоос-  
<http://happyhome.mn/index.php/site/property/2638-оор> тус тус авч болно.

Санхүү, эдийн засгийн хэлтэс нь тайлант хугацаанд татвар, нийгмийн даатгалын хуулиудаар хүлээсэн үүргээ биелүүлж

Сар бүр

- НӨАТ-ын тайланг
- Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан

Улирал бүр

- ААНОАТатварын тайлан
- ХХОАТатварын тайлан

Хагас жил болон Жилийн эцсээр

- Санхүү байдлын дэлгэнгүй тайлан /БАЛАНС /
- Тээврийн хэрэгслийн татварын тайлан
- Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тайлан
- Тус тус бэлтгэн хуулийн хугацаанд зохих байгууллагуудад тушаасан байна.
- Тайлант онд Монгол улсын төсөв болон орон нутгийн төсөвт :
- АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРТ : 46,510,000 ₮
- НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРТ : 1,528,546,000 ₮
- ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРТ : 72,820,000 ₮
- ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТАТВАРТ : 11,200,000 ₮
- ИМПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРТ : 307,259,000 ₮
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРТ : 813,000 ₮
- ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ : 1,920,000 ₮
- ГАЗРЫН ТӨЛБӨРТ : 65,079,520 ₮

**НИЙТ: 2,034,147,520 оруулсан байна.**

Орлого буурсан шалтгааны нэг бол Монгол Улсын Засгийн газраас гурилын импортыг хориглосноос ОХУ-аас орж ирдэг гурилын вагон зогссон ба үүнээс улбаалан түрээсийн агуулах суларсан.

Мөн ОХУ Украин улсаас дамжин өнгөрөх тээврийг хориглосноос чихэр, импортоор оруулж ирдэг компаниудын ачаа барааны тоо эрс цөөрсөн явдал юм.

Гадаад Харилцаа Хамтын Ажиллагааны Хэлтэс нь 2017 онд нийт 1392 чингэлэг, 155 битүү вагонтой ачааны импортын тээвэр, 7 ширхэг түүвэр ачаа, 3 чингэлэгийн экспортын тээвэр зохион байгуулсан байна.

Чингэлэгээр тээвэрлэсэн ачаа барааны 56 %-ийг шинэ ба хуучин машин, автомашины сэлбэг, 38 %-ийг хүнсний бүтээгдэхүүн, үлдсэн 6 %-ийг гэр ахуйн бараа,

тавилга ба барилгын материал гэх зэрэг бараа эзэлж байна. Урьд оныхтой харьцуулбал хуучин ба шинэ машины тээвэрлэлт 45% , хүнсний барааны тээвэрлэлт 30%, харин гэр ахуй, тавилга ба барилгын материалын тээвэрлэлт 33%-иар, хөргүүртэй чингэлэгийн тээвэр 40%-иар тус тус өссөн байна.

Улс	Украйн	Япон	Малайз	Вьетнам	БНХАУ	Филиппин	Солонгос	Бельги	Турк	Шинэ Зеланд	Энэтхэг	Итали	Герман	Бусад	Нийт
Нийт	27	75		12											142
Хувиар %	4	9	45	6	22	20	49	11	26	18	14	8	9	48	9
Хувиар %	19	53	3.2	9	1.5	1.5	3.4	0.9	1.8	1.3	0.9	0.6	0.6	3.3	100 %

Дээрх хүснэгтэд өнгөрсөн онд хүлээн авсан чингэлэг болон вагонтой ачааны гарал үүслийг үзүүлэв. Нийт ачааны 53 % нь Centrowide Japan, Central Express Line, Knot Global, SYNC, Transbridge, Sinoworlink, Jinli Sealand, Huidong зэрэг компаниудын шугамаар Япон улсаас, 19% нь Фосдайк, Жиаёоу зэрэг компаниудын шугамаар Украин улсаас, 11% нь Хуйдун болон Eurasia Logistics компанийн шугамаар Вьетнам улсаас, 3,4% нь Chung Jo Shipping, General Logistic, Korail, Wonnam, BOGO International компаниудын шугамаар БНСУ, 3.2% нь Хуйдун, Жинли компаниудын шугамаар Малайзаас, бусад ачаа нь БНХАУ, Латин Америк, Зүүн өмнөд Ази, Европын орнуудаас тус тус тээвэрлэгдсэн байна.

2017 онд ердийн чингэлэгүүдээс гадна 10 хөргүүртэй чингэлэг импортоор хүлээн авсан нь өнгөрсөн онтой харьцуулбал 10%-иар нэмэгдсэн байна.

Өнгөрсөн онд хүлээж авсан вагоны тоотой харьцуулж үзвэл 29 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Вагоны тээврийн гол ачаа нь гурил, будаа, масло, гоймон, давс, ургамлын тос, элсэн чихэр, бүх төрлийн чихэр, печень, овъёос, малын тэжээл, хивэг, барилгын материал, ундаа зэрэг болно. Жингээр нь дүгнэж үзвэл Гаалийн Хяналтын Бүсийн хэмжээнд нийт 55010 тонн вагонтой ачаа хүлээн авсан байна.



Өнгөрсөн онд нийт талбайн хэмжээнд хүлээж авсан чингэлгийн тоотой харьцуулбал 34 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Жингээр нь дүгнэж үзвэл, Гаалийн Хяналтын Бүсийн хэмжээнд нийт 57733 тонн чингэлэгтэй ачаа хүлээн авчээ.

2017 онд гадаадын харилцагч агентуудын найдвартай түргэн шуурхай хамтын ажиллагаа, хямд үнэ, чанартай үйлчилгээнд онцгой анхаарч ажилласан ба нийт 30 орчим гадаадын тээврийн агенттай хамтран ажиллаа. Үүнд:

БНХАУ-ын Jinli Sealand, Sino-Worlink International, Huidong, Jiayou Logistics, Трансбридж, World Jaguar, Cosco, Sinotrans, Туркийн Logimar Logistics, Японы Centrowide, Central Express Line, Techno Trans, Knot Global, SYNC, Солонгосын Chung Jo, General Logistics, Wonnam, Korail, BOGO International, Арабын ASV Shipping, KJK Shipping, Вьетнамын Eurasia Logistics, Литва улсын Logipolija, Германы RTSB гэх мэт.

Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн буюу 2 мэдүүлэгч 2017 онд өөрийн компанийн болон бусад тээвэр зуучлалын байгууллагуудын тээвэрлэн авчирч байгаа ААН болон хувь хүмүүсийн импортын бараа, тээврийн хэрэгслийг холбогдох бичиг баримтын хамт үнэн зөв бүрдүүлэн, гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн бүрдүүлэлтийн ажлыг хийлээ. Түүнээс гадна Гаалийн байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж, тавьсан шаардлагыг биелүүлэн, гаалийн хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллаа.

Үйлдвэр техникийн хэлтэс Нэг цэгийн үйлчилгээний төв оффис, хуучин оффисын дотор болон талбайн камержуулалт, цэвэр бохир, дулаан, цахилгаан холболт, компанийн ачаа эргэлт, үйлдвэрлэлийн өргөх буулгах механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тогтвортой хэвийн жигд ажиллагааг хангах, зорилгоо амжилттай хэрэгжүүлж, вандан кранууд болон машин механизмуудын үзлэг үйлчилгээг тогтмолжуулан, гарсан гэмтэл, илэрсэн доголдлыг тухай бүрт нь засварлан хэвийн ажиллуулж ирлээ.

Энэ онд урьд жилүүдтэй харьцуулахад техникүүдийн эвдрэл гэмтэл, засварын болон сэлбэгийн зардлыг эрс багасгаж компанийн үйл ажиллагаанд томоохон хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Үүнд машин механизм тоног төхөөрөмж болон крануудын дунд ба урсгал засвар, краны болон вагон зам засвар арчилгааг хийлгүүлсэн, компанид байгаа сэлбэг, материалыг аль болох түлхүү ашигласан зэрэг өөрсдийн зүгээс хэмнэж болох бүхий л арга хэмжээг авч ажиллаа.

Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Хэлтэс 2017 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ❖ “МКЛ” мэргэжлийн сургалтын төвтэй хамтран тусгай мэргэжлийн үнэмлэхтэй ажиллагсдын дүрмийн мэдлэгийн давтан, шинээр Кранаар ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч мэргэжлээр 1 хүнийг сургалтад хамруулж, зохих үнэмлэх сертификатыг авлаа.
- ❖ Баянгол дүүргийн Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран Гамшиг осолд өртөгсдөд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх нийт 15 хүнд 24 цагийн сургалт зохион байгуулсан.

- ❖ Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2 удаа агаарын бохирдлын талаар сургалт явуулсан.
- ❖ Компанийн удирдлага, үйлдвэр, алба, хэлтсийн дарга нартай эргүүл үзлэг шалгалт хийж, мэргэжлийн хяналтын байцаагч, Шунхлай СӨХ-ны даргатай хамтран Голден парк хотхоны орц гарцын талаар уулзалт зохион байгуулсан.
- ❖ Хөдөлмөрийн Эрүүл Мэндийн Төвтэй хамтран эмч нарын багийг байгууллага дээрээ авчиран нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг 8, заавал хийгдэх шинжилгээ 8, нэмэлтээр хийгдэх 2, нийт 18 үзлэг шинжилгээнд нийт 56 ажиллагсдыг хамруулсан. Ажилтан тус бүрт эрүүл мэндийн хуудас, амбулаторийн карт нээж, үзлэгийн дүнг бичин, эмчилгээ зааж, уг өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өглөө.
- ❖ Үйлдвэрийн байр болон хэлтсүүдэд байх Эмийн сангуудад нөхөн хангалт цаг тухай бүрт хийсэн.
- ❖ Ажиллагсдын нормын хувцас хэрэглэлийг Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж “Дархан нэмэх” ХХК-тай гэрээ хийн 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна.
- ❖ Нийслэл болон дүүрэг, Онцгой байдал, Төмөр замын цагдаагийн газар, Ажил олгогч эздийн холбоо, ХАБ-н ажилчдын зохион байгуулж байгаа бүхий л арга хэмжээнүүдэд идэвх, санаачлагатай оролцож байгаа болно.
- ❖ Ажиллагсдад урьдчилсан болон ээлжит, ээлжит бус, давтан зааварчилгыг цаг тухайд нь өгч компанийн нийт ажиллагсад, талбай, үйлдвэр, дайвар үйлчлүүлэгч компани, үйлчлүүлэгч нарт хяналт тавин заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

2017 онд бид компанийнхаа үүсгэн байгуулагдсан түүхт 60 жилийн ойн арга хэмжээг хамт олноороо амжилттай зохион байгуулж, гадаад дотоодын харилцагч бүхий л байгууллагын төлөөлөгчдийн урьж, ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлэн баярын хурал, хүндэтгэлийн зоог барин, хамт олноороо Байгаль нуур-Улаан-үдийн 5 хоногийн аялал зохион байгуулж, спортын 5 төрөлд эрч хүч, ид хав, үзүүр түрүүг уралдан тэмцэлдлээ. Мөн “Их үйлсийн жаран жил” хэмээх дурсамж номтой боллоо.

2017 он бидний хувьд шагналын хур буусан сайхан жил байлаа. МҮХАҮТанхимын Хийморь одон 1, танхимын “ENTREPRENEURSHIP SPIRIT” хүндэт тэмдэг 1, танхимын Хүндэт жуух бичиг 1, “Тэргүүний барилгачин” 4, Барилга, хот байгуулалтын яамны Хүндэт жуух 1, “Онц тээвэрчин” 1, Ард түмний гавьяат 1, Барилга, хот байгуулалтын яамны Жуух бичиг 1, Сангийн яамны Жуух бичиг 3, ХЗДХЯамны Жуух бичиг 1, Нийгмийн даатгалтын жуух бичиг 1, Нийгмийн даатгалын Тэргүүний ажилтан 1, БОАЖЯамны Жуух бичиг 1, Монгол улсад барилгын салбар болон зураг төслийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн хүндэт тэмдэг 15, Ахмадын холбооны Хүндэт тэмдэг 5, МЗХолбооны цол тэмдэг 16, компанийн Өргөмжлөл 12, нийт ажиллаж байсан ахмад буурлууд, одоо ажиллаж байгаа ажилтан албан хаагч гээд 6 хүнийг шагнаж урамшуулсан байна. Үүн дээр харилцагч байгууллагуудаас ч биднийг шагнаж урамшуулсан билээ.

“МАТЕРИАЛИМПЭКС” ХК